



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2020 оны 03 сарын 11 өдөр

Дугаар 120

Улаанбаатар хот

“Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, эрх олголт, бүртгэлийн журам батлах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, 6.3.1, 6.3.2, 6.3.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, эрх олголт, бүртгэлийн журам”-ыг хавсралтаар баталсугай.

2. Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авах хүсэлтээ 2020 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлэхийг үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж буй хуулийн этгээдүүдэд үүрэг болгосугай.


3. Энэхүү тогтоолын 2 дахь заалтыг хэрэгжүүлээгүй хуулийн этгээдэд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу арга хэмжээ авч ажиллахыг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд үүрэг болгосугай.

4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН



ҮЛ ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГӨ ЗУУЧЛАЛЫН БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ, ЗӨВШӨӨРӨЛ, ЭРХ ОЛГОЛТ, БҮРТГЭЛИЙН ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь Санхүүгийн зохицуулах хороо /цаашид “Хороо” гэх/-ноос үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагаа эрхлэхэд тавигдах шаардлагыг тодорхойлох, тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олгох, бүртгэх, тэдгээрийг түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгохтой холбоотой нарийвчилсан харилцааг зохицуулахад оршино.

1.2. Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллага нь тусгай зөвшөөрлийн хүрээнд дараах үйлчилгээ эрхэлнэ:

1.2.1. үл хөдлөх эд хөрөнгө, түүнтэй холбоотой эрхийг худалдах, худалдан авах, шилжүүлэх үйл ажиллагааг зуучлах;

1.2.2. үл хөдлөх эд хөрөнгө, түүнтэй холбоотой эрхийг түрээслүүлэх, түрээслэх, хөлслүүлэх, хөлслөх үйл ажиллагааг зуучлах;

1.3. Тусгай зөвшөөрөлтэй үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллага нь дараах үйлчилгээг эрхэлж болох бөгөөд тухай бүр энэ журамд заасны дагуу Хороонд бүртгүүлнэ:

1.3.1. үл хөдлөх эд хөрөнгийн менежментийн үйлчилгээ;

1.3.2. үл хөдлөх эд хөрөнгийг худалдан авч, засварлан борлуулах үйлчилгээ;

1.3.3. Хорооноос үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын үйл ажиллагаанд хамаарна гэж үзсэн бусад үйлчилгээ.

1.4. Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагааг энэ журамд заасан тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээд эрхэлнэ.

Хоёр. Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход тавигдах шаардлага

2.1. Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдийн хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээ нь 15,000,000.0 /арван таван сая/ төгрөг байх бөгөөд дараах нөхцөл, шаардлагыг хангасан байна:

2.1.1. Компанийн тухай хуульд заасны дагуу үүсгэн байгуулагдсан, улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлсэн байх;

2.1.2. Хорооноос тогтоосон хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг хангасан байх;

2.1.3. хувь нийлүүлсэн хөрөнгийг мөнгөн хөрөнгөөр бүрдүүлэх бөгөөд зээлийн эх үүсвэрээр бүрдүүлээгүй, хууль ёсны орлого байх;

2.1.4. үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын агентаар 2-оос доошгүй жил ажилласан туршлагатай, агентуудыг мэргэшил, арга зүйгээр хангаж ажиллах, энэ журмын 1.2.1, 1.2.2-т заасан үйлчилгээг үзүүлэх чиг үүрэгтэй 1-ээс доошгүй брокертой байх;

2.1.5. энэ журмын 1.2.1, 1.2.2-т заасан үйлчилгээг үзүүлэх чиг үүрэгтэй 1-ээс доошгүй агенттай байх;

2.1.6. брокер, агент нь Хорооноос баталсан сургалтын хөтөлбөрийн дагуу зохион байгуулагдсан сургалтад хамрагдаж, шалгалтад тэнцэж, гэрчилгээ авсан байх;

Тайлбар /2020 оны 6 дугаар сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын чиглэлээр холбогдох сургалтад хамрагдаж брокер, агентын гэрчилгээ авсан бол энэ журмын 2.1.6-д заасан шаардлагыг хангасанд тооцно./

2.1.7. энэ журмын 5 дугаар бүлэгт заасан тохиромжтой этгээдийг тодорхойлох шалгуурыг хангасан байх;

2.1.8. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих ажилтан томилсон байх;

2.1.9. үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын үйл ажиллагаа явуулах ажлын байр, техник, тоног төхөөрөмж, програм хангамжтай байх;

2.1.10. үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын үйл ажиллагааг зохицуулсан дотоод журам, ажилтнуудын ёс зүйн журам, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд заасан дотоод хяналтын болон эрсдэлийн удирдлагын хөтөлбөртэй байх;

2.1.11. бизнес төлөвлөгөөтэй байх;

2.1.12. энэ журмын 1 дүгээр хавсралт дахь маягтын дагуу өргөдөл гаргаж, 4 дүгээр хавсралтад заасан баримт бичгийг үнэн зөв, бүрэн гүйцэд бүрдүүлэн Хороонд ирүүлсэн байх.

2.2. Гадаадын хөрөнгө оруулалттай үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллага нь Хөрөнгө оруулалтын тухай хууль болон энэ журмын 2.1-д заасан шаардлагаас гадна дараах шаардлагыг хангасан байна:

2.2.1. хөрөнгө оруулах этгээдийн мөнгөн хөрөнгийн гарал үүсэл, үйл ажиллагааны талаар тухайн улсын холбогдох төрийн байгууллага эсхүл хууль хяналтын байгууллага, банк санхүүгийн байгууллагаас мэдээлэл, тодорхойлолт, лавлагаа авсан байх;

2.2.2. хөрөнгө оруулж буй мөнгөн хөрөнгийн дүн, гарал үүслийн талаар Монгол Улсын Санхүүгийн мэдээллийн албанд мэдээллээ хүргүүлсэн байх.

2.3. Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллага нь дараах нийтлэг шаардлагуудыг хангаж ажиллана:

2.3.1. Монгол Улсын Иргэний хууль, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль, Компанийн тухай хууль, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль болон бусад хууль тогтоомж, Хорооноос баталсан заавар, журмыг мөрдөж ажиллана.

2.3.2. Хорооноос баталсан журмын дагуу жил бүр болон тухай бүр төвлөрүүлэх зохицуулалт үйлчилгээний хөлсийг тогтоосон хэмжээгээр хугацаанд нь төвлөрүүлнэ.

2.3.3. холбогдох хууль тогтоомжийн дагуу Хорооны хяналт, шалгалтад хамрагдана.

Гурав. Тусгай зөвшөөрөл олгох, олгохоос татгалзах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох

3.1. Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл /цаашид “тусгай зөвшөөрөл” гэх/ хүсэж ирүүлсэн өргөдөл, баримт бичгийг Хорооны холбогдох ажилтан хянаж, зөвлөгөө өгөх бөгөөд тухайн өргөдөл, баримт бичгийн бүрдүүлбэр, шаардлагыг хангасан гэж үзвэл Хорооны бичиг хэрэгт бүртгүүлнэ.

3.2. Тусгай зөвшөөрөл олгох эсэхийг тусгай зөвшөөрөл хүсэж ирүүлсэн өргөдөл, холбогдох баримт бичгийг үнэн зөв, бүрэн гүйцэд, холбогдох хууль тогтоомж, энэхүү журамд заасан шаардлагуудыг хангаж ирүүлсэн өдрөөс эхлэн ажлын 30 хоногийн дотор Хорооны хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэх бөгөөд шаардлагатай тохиолдолд хугацааг ажлын 14 хоногоор сунгаж болно.

3.3. Тусгай зөвшөөрлийг хугацаагүйгээр олгох бөгөөд тус шийдвэрт тухайн хуулийн этгээдийн эрхлэх үйлчилгээний төрлийг тодорхой тусгана.

3.4. Тусгай зөвшөөрөл олгосон тухай шийдвэрийг үндэслэн Хороо тусгай зөвшөөрлийн гэрчилгээг олгож, нэгдсэн бүртгэлд бүртгэн, зохих зааврын дагуу хувийн хэрэг нээн хөтөлнө.

3.5. Энэ журмын 3.4-т заасан Хорооны шийдвэрийг үндэслэн үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдийг Улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлснээр үйл ажиллагаа эхлүүлсэнд тооцно.

3.6. Тусгай зөвшөөрөл олгогдсонтой холбоотой өөрчлөлтийг энэ тухай шийдвэр гарснаас хойш ажлын 15 хоногийн дотор Улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлж, нотариатаар гэрчлүүлсэн улсын бүртгэлийн гэрчилгээ болон дүрмийн хуулбарыг Хороонд ирүүлнэ.

3.7. Өргөдлийн мэдээлэл, бүрдүүлсэн баримт бичигтэй холбоотой нэмж тодруулах зайлшгүй шаардлагатай гэж үзвэл Хороо энэ талаар албан бичгээр мэдэгдэж, нэмэлт мэдээлэл, баримт бичиг шаардах эрхтэй бөгөөд хууль, журмын шаардлагын дагуу нэмж бүрдүүлж ирүүлсэн өдрөөс эхлэн шийдвэрлэх хугацааг тооцно.

3.8. Хороо нь дараах үндэслэлээр үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгохоос татгалзана:

3.8.1. энэ журмын 2.1-д заасан шаардлагыг хангаагүй;

3.8.2. тусгай зөвшөөрөл хүсэж ирүүлсэн баримт бичиг нь шаардлага хангаагүй, баримт бичгийг хуурамчаар үйлдсэн нь тогтоогдсон;

3.8.3. тусгай зөвшөөрөл хүсэж ирүүлсэн баримт бичгийг энэхүү журмын шаардлагад нийцэхүйц хэмжээнд бүрдүүлэх хугацаа нь хүсэлт тавьсан өдрөөс хойш 6 сарын хугацаатай байх бөгөөд тус хугацаа өнгөрсөн;

3.8.4. хууль тогтоомжид заасан бусад нөхцөл, шаардлагыг хангаагүй.

3.9. Тусгай зөвшөөрөл олгохоос татгалзсан тохиолдолд Хороо энэ талаарх үндэслэл бүхий тайлбарыг өргөдөл гаргагчид албан бичгээр мэдэгдэнэ.

3.10. Хуурамч баримт бичиг бүрдүүлсэн гэдэг үндэслэлээр татгалзсан өдрөөс хойш тухайн өргөдөл гаргагч хуулийн этгээдээс тусгай зөвшөөрөл хүссэн өргөдлийг 1 жилийн дотор дахин хүлээн авахгүй.

3.11. Хороо нь тусгай зөвшөөрлийг дараах үндэслэлээр Хорооноос тавьсан шаардлага, өгсөн үүрэг даалгаврыг биелүүлэх хүртэл 3 сар хүртэл хугацаагаар түдгэлзүүлнэ:

3.11.1. энэ журам болон бусад холбогдох хууль тогтоомжийг зөрчсөн, тэдгээрт заасан шаардлагыг хангаагүй;

3.11.2. үйлчлүүлэгч болон нийтийн ашиг сонирхолд хохирол учруулсан талаар анхан шатны шүүхийн шийдвэр гарсан;

3.11.3. холбогдох хууль тогтоомжийн дагуу Хорооноос өгсөн үүрэг даалгаврыг биелүүлээгүй;

3.11.4. Хорооноос тогтоосон хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг хангаж ажиллаагүй;

3.11.5. энэ журмын 5 дугаар зүйлд заасан тохиромжтой этгээдийг тодорхойлох шалгуурыг хангахгүй болсон, Хорооноос тохиромжтой бус этгээд гэж үзсэн;

3.11.6. тусгай зөвшөөрөл олгосноос хойш 1 жилийн дотор үйл ажиллагаагаа эхлээгүй, эсхүл үйл ажиллагаагаа зогсоосон;

3.11.7. Хорооноос тогтоосон зохицуулалт үйлчилгээний хөлс төлөх хугацааг 3 сараас дээш хугацаагаар хэтрүүлсэн;

3.11.8. ирүүлбэл зохих тайлан, мэдээг 3 улирал дараалан ирүүлээгүй;

3.11.9. хууль, журамд заасан бусад үндэслэл.

3.12. Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэхээс өмнө Хороо тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх үндэслэлийг заасан мэдэгдлийг тусгай зөвшөөрөл эзэмшигчид албан бичгээр хүргүүлж, хүргэсэн огноог тэмдэглэнэ.

3.13. Тусгай зөвшөөрөл эзэмшигч энэ журмын 3.12-т заасан мэдэгдлийг хүлээн авснаас хойш ажлын 14 хоногийн дотор тусгай зөвшөөрлийг нь түдгэлзүүлэх үндэслэлгүй гэж үзсэн тухай тайлбараа Хороонд албан бичгээр ирүүлээгүй бол тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлнэ.

3.14. Ирүүлсэн тайлбарыг үндэслэлгүй, гаргасан зөрчил арилаагүй гэж үзвэл Хороо тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлнэ.

3.15. Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн тохиолдолд дараах агуулга бүхий мэдэгдлийг тусгай зөвшөөрөл эзэмшигчид албан бичгээр хүргүүлнэ:

3.15.1. тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн тухай;

3.15.2. тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн үндэслэл, түдгэлзүүлж эхэлсэн огноо;

3.15.3. тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн хугацаа.

3.16. Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн тохиолдолд түдгэлзүүлсэн үндэслэл болсон зөрчил дутагдлыг арилгаж хэвийн үйл ажиллагаагаа хангасан тохиолдолд тухайн хуулийн

этгээдийн хүсэлтийг үндэслэн сэргээнэ. Тусгай зөвшөөрлөө сэргээлгэх хүсэлтэй хуулийн этгээд нь энэхүү журмын 10 дугаар хавсралтад заасан баримт бичгийг хүсэлтийн хамт хавсаргаж Хороонд ирүүлнэ.

3.17. Хороо дараах үндэслэлээр тусгай зөвшөөрлийг хүчингүй болгоно:

3.17.1. тусгай зөвшөөрөл эзэмшигч хүсэлт гаргасан;

3.17.2. тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээд татан буугдсан;

3.17.3. тусгай зөвшөөрлийг авахдаа хуурамч баримт бичиг бүрдүүлсэн нь тогтоогдсон;

3.17.4. тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг 3 буюу түүнээс дээш удаа дараа зөрчсөн;

3.17.5. тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн хугацаанд зөрчлийг арилгах талаар тавьсан шаардлагыг биелүүлээгүй;

3.17.6. ирүүлбэл зохих тайлан, мэдээг хугацаанд нь удаа дараалан ирүүлээгүй, хяналт, шалгалт хийх боломжгүй болгож, тайланг 4 улирал дараалан Хороонд ирүүлээгүй;

3.17.7. хууль тогтоомжид заасан бусад үндэслэл.

3.18. Тусгай зөвшөөрөл эзэмшигч тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох хүсэлт гаргаж буй тохиолдолд энэхүү журмын 11 дүгээр хавсралтад заасан баримт бичгийг хүсэлтийн хамт хавсаргаж Хороонд ирүүлнэ.

3.19. Тусгай зөвшөөрлийг хүчингүй болгохоос өмнө Хороо тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох болсон үндэслэлийг заасан мэдэгдлийг тусгай зөвшөөрөл эзэмшигчид албан бичгээр хүргүүлж, хүргэсэн огноог тэмдэглэнэ.

3.20. Тусгай зөвшөөрөл эзэмшигч энэ журмын 3.19-д заасан мэдэгдлийг хүлээн авснаас хойш ажлын 14 хоногийн дотор тусгай зөвшөөрлийг нь хүчингүй болгох үндэслэлгүй гэж үзсэн тухай тайлбараа Хороонд албан бичгээр ирүүлээгүй бол тусгай зөвшөөрлийг хүчингүй болгоно.

3.21. Ирүүлсэн тайлбарыг үндэслэлгүй, гаргасан зөрчил арилаагүй гэж үзвэл Хороо тусгай зөвшөөрлийг хүчингүй болгоно.

3.22. Тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон тохиолдолд дараах агуулга бүхий мэдэгдлийг тусгай зөвшөөрөл эзэмшигчид Хороо албан бичгээр хүргүүлнэ:

3.22.1. тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон тухай;

3.22.2. тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон үндэслэл, огноо.

3.23. Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн болон хүчингүй болгосон тухай мэдэгдлийг хүлээн авсан өдрөөс хойш хийсэн дараах үйл ажиллагааг хүчин төгөлдөр бус гэж үзнэ:

3.23.1. тусгай зөвшөөрөлтэй эрхлэх үйл ажиллагааны чиглэлээр шинээр аливаа гэрээ, хэлцэл байгуулах;

3.23.2. тусгай зөвшөөрөлтэй эрхлэх үйл ажиллагааны чиглэлээр тухайн өдрөөс өмнө байгуулсан аливаа гэрээ, хэлцэлд нэмэлт өөрчлөлт оруулах.

3.24. Хороо тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн болон хүчингүй болгосон талаарх мэдээллийг нийтэд мэдээлнэ.

3.25. Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн болон хүчингүй болгосноос учирсан аливаа хохирлыг Хороо хариуцахгүй.

3.26. Хорооноос тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон шийдвэр гаргаснаар үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа нь дуусгавар болно.

3.27. Хороо тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн, хүчингүй болгосон шийдвэр гаргасан өдрөөс хойш үйл ажиллагааг үргэлжлүүлбэл тусгай зөвшөөрөлгүйгээр үйл ажиллагаа эрхэлсэн гэж үзэн холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэх үндэслэл болно.

3.28. Тусгай зөвшөөрөлтэй үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллага нь зөвхөн үл хөдлөх эд хөрөнгийн салбарт үйл ажиллагаа эрхэлнэ.

Дөрөв. Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагаатай холбогдох зөвшөөрөл олгох, олгохоос татгалзах, хүчингүй болгох

4.1. Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллага нь өөрийн үйл ажиллагаатай холбоотой дараах өөрчлөлтүүдийг оруулахын өмнө тухай бүр Хороонд мэдэгдэж, зөвшөөрөл авна:

4.1.1. хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, хувьцаа эзэмшигчдийн бүтэц, бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах;

4.1.2. салбар байгуулах;

4.1.3. оноосон нэр өөрчлөх.

4.2. Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагаа эрхлэх этгээд нь хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, хувьцаа эзэмшигчдийн бүтэц, бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулахын өмнө зөвшөөрөл авах бөгөөд дараах шаардлага тавигдана:

4.2.1. хувь нийлүүлсэн хөрөнгийг нэмэгдүүлсэн мөнгөн хөрөнгө нь хууль ёсны орлогоос бүрдсэн байх;

4.2.2. хувьцаа эзэмшигч өөрчлөгдөж байгаа бол энэ журмын 5 дугаар бүлэгт заасан тохиромжтой этгээдийг тодорхойлох шалгуурыг хангасан байх;

4.2.3. үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагаа эрхлэх этгээдийн хувьцааг худалдан авч буй хувьцаа эзэмшигчийн хөрөнгийн гарал үүсэл нь хууль ёсны орлогоос бүрдсэн байх;

4.2.4. энэ журмын 2 дугаар хавсралт дахь маягтын дагуу өргөдөл гаргаж, 5 дугаар хавсралтад заасан баримт бичгийг үнэн зөв, бүрэн гүйцэд бүрдүүлэн Хороонд ирүүлсэн байх.

4.3. Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллага нь хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, хувьцаа эзэмшигчдийн бүтэц, бүрэлдэхүүнд дараах хэлбэрээр өөрчлөлт оруулж болно:

4.3.1. хувьцаа эзэмшигчдийн мөнгөн хөрөнгөөр;

4.3.2. үндсэн үйл ажиллагааны хуримтлагдсан ашгаас хуваарилсан ногдол ашгаар нэмж хөрөнгө оруулах;

4.3.3. хувьцаа нэмж гаргах.

4.4. Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын салбар байгуулах зөвшөөрөл олгоход дараах шаардлага тавигдана:

4.4.1. үйл ажиллагаа явуулах хаяг, байршил нь тодорхой, байнгын ажлын байртай байх;

4.4.2. үйл ажиллагаа хэвийн явуулах тоног төхөөрөмж, програм хангамжтай байх;

4.4.3. салбарын үйл ажиллагааг зохицуулах журамтай байх;

4.4.4. Хорооноос баталсан сургалтын хөтөлбөрийн дагуу зохион байгуулагдсан сургалтад хамрагдаж, шалгалтад тэнцэж, гэрчилгээ авсан 1-ээс доошгүй брокертой байх;

4.4.5. Хорооноос баталсан сургалтын хөтөлбөрийн дагуу зохион байгуулагдсан сургалтад хамрагдаж, шалгалтад тэнцэж, гэрчилгээ авсан 1-ээс доошгүй агенттай байх;

4.4.6. энэ журмын 2 дугаар хавсралт дахь маягтын дагуу өргөдөл гаргаж, 6 дугаар хавсралтад заасан баримт бичгийг үнэн зөв, бүрэн гүйцэд бүрдүүлэн Хороонд ирүүлсэн байх;

4.5. Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын оноосон нэр өөрчлөх зөвшөөрөл олгоход дараах шаардлага тавигдана:

4.5.1. тусгай зөвшөөрөл эзэмшигч нь оноосон нэрээ өөрчлөх нь үйлчлүүлэгчдэд сөргөөр нөлөөлөхгүй, төөрөгдүүлэхгүй байх;

4.5.2. энэ журмын 2 дугаар хавсралт дахь маягтын дагуу өргөдөл гаргаж, 7 дугаар хавсралтад заасан баримт бичгийг үнэн зөв, бүрэн гүйцэд бүрдүүлэн Хороонд ирүүлсэн байх.

4.6. Зөвшөөрөл авахаар хүсэж ирүүлсэн өргөдөл, баримт бичгийг Хорооны холбогдох ажилтан хянаж, зөвлөгөө өгөх бөгөөд тухайн өргөдөл, баримт бичгийн бүрдүүлбэр, шаардлагыг хангасан гэж үзвэл Хорооны бичиг хэрэгт бүртгүүлнэ.

4.7. Зөвшөөрөл хүсэж ирүүлсэн өргөдөл, баримт бичгийг хянаж, ажлын 30 хоногийн дотор Хороо шийдвэрлэнэ. Шаардлагатай тохиолдолд хугацааг 14 хоногоор сунгаж болно.

4.8. Зөвшөөрөл олгох тухай Хорооны шийдвэрийг үндэслэн тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хавсралтад зохих тэмдэглэгээг хийж, баталгаажуулсны дараа Улсын бүртгэлийн байгууллагад ажлын 5 өдрийн дотор хүргүүлж, холбогдох бүртгэлийг хийлгэнэ.

4.9. Хуулийн этгээд нь Улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлсэн буюу өөрчлөлт оруулсан улсын бүртгэлийн гэрчилгээ болон дүрмийн нотариатаар гэрчлүүлсэн хуулбарыг Хороонд ирүүлнэ.

4.10. Салбар нь Хорооноос олгогдсон зөвшөөрлийн үндсэн дээр үйл ажиллагаа эрхлэх бөгөөд салбар тус бүр зөвшөөрлийн гэрчилгээтэй байна.

4.11. Хорооны зөвшөөрөлгүйгээр энэ журмын 4.1-д заасан өөрчлөлтүүдийг оруулсан тохиолдолд зөвшөөрөлгүйгээр үйл ажиллагаа эрхэлсэн гэж үзэн холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэх үндэслэл болно.

4.12. Хорооноос тавьсан шаардлагыг хангаагүй тохиолдолд зөвшөөрөл олгохоос татгалзах бөгөөд энэ тухай албан бичгээр мэдэгдэнэ.

4.13. Салбарын зөвшөөрлийг дараах үндэслэлээр хүчингүй болгож зөвшөөрлийн гэрчилгээг хураан авч, нийтэд мэдээлнэ:

4.13.1. салбар татан буулгах эрх бүхий этгээдийн шийдвэр;

4.13.2. холбогдох хууль тогтоомжид нийцээгүй үйл ажиллагаа явуулсан, Хорооноос өгсөн үүрэг даалгаврыг биелүүлээгүй эсвэл салбарын үйл ажиллагаа нь тухайн хуулийн этгээдийн үйл ажиллагаанд хүндрэл учруулахаар байгааг тогтоосны үндсэн дээр гаргасан Хорооны шийдвэр.

Тав. Тохиромжтой этгээдийг тодорхойлох шалгуур

5.1. Тохиромжтой этгээдийг тодорхойлох шалгуурт үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөл гаргагч хуулийн этгээд, түүний эрх бүхий албан тушаалтан, хувьцаа эзэмшигч болон брокер хамаарна.

5.2. Тохиромжтой этгээдийг дараах байдлаар тодорхойлно:

5.2.1. дээд эсхүл бүрэн дунд боловсрол эзэмшсэн байх;

5.2.2. мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, авилга, хээл хахууль, эдийн засгийн гэмт хэрэгт ял шийтгүүлж байгаагүй;

5.2.3. сүүлийн 5 жилийн хугацаанд салбарын ёс зүйн дүрмийг зөрчөөгүй байх,

5.2.4. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд харшлаагүй байх;

5.2.5. хуулийн этгээдийн хувьд энэ журмын 5.2.1. 5.2.3 дэх заалт хамаарахгүй.

5.2.6. энэ журмын 5.2.1 дэх заалт нь үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын хувьцаа эзэмшигчид хамаарахгүй.

5.3. Хороо тохиромжтой этгээдийн шалгуурыг тодорхойлохдоо Монгол Улсын болон гадаад улсын Засгийн газрын агентлаг, мэргэжлийн байгууллага, зохицуулалтын бусад байгууллага, хууль хяналтын байгууллагаас мэдээлэл, лавлагаа авч болно.

5.4. Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын үйл ажиллагаа эрхлэх этгээд, түүний эрх бүхий албан тушаалтан, хувьцаа эзэмшигч, брокер нь энэ журамд заасан тохиромжтой этгээдийн шалгуурыг байнга хангаж ажиллана. Тохиромжтой этгээдийг тодорхойлох шалгуурыг хангаж байгаа эсэхэд улсын байцаагч, хянан шалгагч нар зайны болон газар дээрх хяналт шалгалтаар байнгын хяналт тавина.

Зургаа. Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагаатай холбогдох бүртгэл

6.1. Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллага нь 1.3-д заасан үйлчилгээ эрхлэхдээ энэ журмын 3 дугаар хавсралт дахь маягтын дагуу өргөдөл гаргаж, 8 дугаар хавсралтад заасан баримт бичгийг үнэн зөв, бүрэн гүйцэд бүрдүүлэн Хороонд ирүүлж, бүртгүүлнэ.

6.2. Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллага нь дараах өөрчлөлтүүдийг оруулахын өмнө тухай бүр Хороонд мэдэгдэж, бүртгүүлнэ:

6.2.1. үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын эрх бүхий албан тушаалтан өөрчлөгдөх;

6.2.2. үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын брокер, агент өөрчлөгдөх;

6.2.3. үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллага болон түүний салбарын хаяг өөрчлөгдөх;

6.3. Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын эрх бүхий албан тушаалтан өөрчлөгдөн томилогдох тухай бүр Хороонд холбогдох баримт бичгийг ирүүлж, хянуулан, бүртгүүлэх бөгөөд уг өөрчлөлтийг бүртгүүлэхэд дараах шаардлага тавигдана:

6.3.1. шинээр томилогдож буй эрх бүхий албан тушаалтан энэ журмын 5 дугаар бүлэгт заасан тохиромжтой этгээдийг тодорхойлох шалгуурыг хангасан байх;

6.3.2. энэ журмын 3 дугаар хавсралт дахь маягтын дагуу өргөдөл гаргаж, 9 дүгээр хавсралтад заасан баримт бичгийг үнэн зөв, бүрэн гүйцэд бүрдүүлэн Хороонд ирүүлсэн байх.

6.4. Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдийн брокер өөрчлөгдөх, шинээр томилогдох тухай бүр Хороонд холбогдох баримт бичгийг ирүүлж, хянуулан, бүртгүүлэх бөгөөд уг өөрчлөлтийг бүртгүүлэхэд дараах шаардлага тавигдана:

6.4.1. брокер нь Хорооноос баталсан сургалтын хөтөлбөрийн дагуу зохион байгуулагдсан сургалтад хамрагдаж, шалгалтад тэнцэж, гэрчилгээ авсан байх;

6.4.2. брокер нь энэ журмын 5 дугаар бүлэгт заасан тохиромжтой этгээдийг тодорхойлох шалгуурыг хангасан байх;

6.4.3. энэ журмын 3 дугаар хавсралт дахь маягтын дагуу өргөдөл гаргаж, 9 дүгээр хавсралтад заасан баримт бичгийг үнэн зөв, бүрэн гүйцэд бүрдүүлэн Хороонд ирүүлсэн байх.

6.5. Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдийн агент өөрчлөгдөх, шинээр томилогдсон тухай мэдээллийг албан бичгээр улирал бүрийн дараа сарын 10-ны өдрийн дотор Хороонд холбогдох баримт бичгийн хамт ирүүлж, бүртгүүлнэ.

6.6. Энэ журамд заасан холбогдох шаардлагыг хангаагүй эсхүл хуурамч бичиг баримт бүрдүүлсэн нь тогтоогдсон тохиолдолд үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын эрх бүхий албан тушаалтан, брокерын өөрчлөлтийг Хороо бүртгэхээс татгалзана.

6.7. Хороо үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагаас ирүүлсэн эрх бүхий албан тушаалтан болон брокер, агентын өөрчлөлтийг бүртгүүлэх хүсэлтийн дагуу бүртгэл хийж, хариуг албан бичгээр мэдэгдэнэ.

6.8. Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын албан ёсны хаяг болон салбарын хаяг өөрчлөгдсөн тохиолдолд ажлын 10 өдрийн дотор энэ журмын 3 дугаар хавсралтаар батлагдсан маягтын дагуу гаргасан өргөдлийг Хороонд албан бичгээр ирүүлж, бүртгүүлнэ.

6.9. Хаягийн өөрчлөлтийг бүртгэсэн бол тухайн зохицуулалттай этгээдийн тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хавсралтад холбогдох тэмдэглэгээг хийнэ.

Долоо. Хяналт, хариуцлага

7.1. Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн болон хүчингүй болгосон тухай Хорооны шийдвэр гарснаас хойш уг үйл ажиллагааг үргэлжлүүлэн эрхэлбэл тусгай зөвшөөрөлгүйгээр үйл ажиллагаа эрхэлсэн гэж үзэж Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай болон холбогдох бусад хуульд заасан хариуцлага хүлээлгэх үндэслэл болно.

7.2. Хороо энэ журмын биелэлтэд хяналт тавьж, зөрчсөн этгээдэд Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль болон холбогдох бусад хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

7.3. Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь энэ журмын 4.1, 6.1-д заасны дагуу Хорооны зөвшөөрөл, бүртгэлгүйгээр аливаа өөрчлөлтийг хийсэн бол холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээнэ.

7.4. Хорооны шийдвэрийг үл зөвшөөрсөн этгээд шийдвэр гарснаас хойш Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 28 дугаар зүйлд заасны дагуу Хорооны дэргэдэх Хяналтын зөвлөлд гомдол гаргаж болно.

Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны 3 дугаар сарын
11-ний өдрийн 42-р тогтоолын хавсралтаар батлагдсан
“Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын
үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл,
эрх олголт, бүртгэлийн журам”-ын 1-р хавсралт



ҮЛ ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГӨ ЗУУЧЛАЛЫН БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ХҮССЭН ӨРГӨДӨЛ

Өргөдөл гаргасан огноо	Он		Сар		Өдөр
Өргөдөл гаргагч хуулийн этгээдийн оноосон нэр	Монгол				
	Англи (Хуулийн этгээдийн нэрийг латин үсгээр галиглан бичнэ)				
Улсын бүртгэлийн дугаар					
Регистрийн дугаар					
Хэсэг 1. Тусгай зөвшөөрөлтэй эрхлэх үйлчилгээний төрлөө сонгоно уу.					
<input type="checkbox"/> Үл хөдлөх эд хөрөнгө, түүнтэй холбоотой эрхийг худалдах, худалдан авах, шилжүүлэх үйл ажиллагааг зуучлах үйлчилгээ					
<input type="checkbox"/> Үл хөдлөх эд хөрөнгө, түүнтэй холбоотой эрхийг түрээслүүлэх, түрээслэх, хөлслөх, хөлслүүлэх үйл ажиллагааг зуучлах үйлчилгээ					
Хэсэг 2. Тусгай зөвшөөрлийн хүрээнд үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдийн мэдээлэл					
Өмнө нь үл хөдлөхийн салбарт үйл ажиллагаа явуулж байсан уу?				Тийм <input type="checkbox"/>	Үгүй <input type="checkbox"/>
Үүсгэн байгуулагдсан огноо	Он		Сар		Өдөр
Хуулийн этгээдийн хэлбэр	<input type="checkbox"/> Хувьцаат компани <input type="checkbox"/> Хязгаарлагдмал хариуцлагатай компани				
Хөрөнгө оруулалтын хэлбэр	<input type="checkbox"/> Дотоодын хөрөнгө оруулалттай <input type="checkbox"/> Гадаадын хөрөнгө оруулалттай				
Хаяг байршил	Аймаг/хот				
	Сум/дүүрэг				
	Баг/хороо				
	Гудамж, байр				
	Тоот				
Холбоо барих утас					
Цахим хуудас					
Цахим хаяг					
Харилцах	Банкны нэр				
	Дансны дугаар				
	Валютын төрөл				
	Үлдэгдэл		₮		₮
Хадгаламж	Банкны нэр				
	Дансны дугаар				

		Валютын төрөл			
		Үлдэгдэл	₮	₮	
Хувь нийлүүлсэн хөрөнгийн талаарх мэдээлэл:					
Хувьцаа эзэмшигчдийн овог нэр/ оноосон нэр	Хувьцааны тоо (ш)	Хувьцааны төрөл		ХНХ-н хэмжээ (₮)	ХНХ-д эзлэх хувь (%)
		<input type="checkbox"/> ДЭХ	<input type="checkbox"/> ЭХ		
		<input type="checkbox"/> ДЭХ	<input type="checkbox"/> ЭХ		
		<input type="checkbox"/> ДЭХ	<input type="checkbox"/> ЭХ		
<i>Тэмдэглэл: (Дээрх мэдээллийг хувьцаа эзэмшигч бүрээр бичнэ.)</i>					
Хэсэг 3. Хувьцаа эзэмшигчдийн талаарх мэдээлэл					
Үүсгэн байгуулагч этгээд нь аль болохыг сонгоно уу.				<input type="checkbox"/> Хуулийн этгээд <input type="checkbox"/> Иргэн	
1. Хувьцаа эзэмшигч нь хуулийн этгээд бол дараах мэдээллийг үнэн зөв бөглөнө үү.					
Хуулийн этгээдийн оноосон нэр	Монгол				
	Англи				
Улсын бүртгэлийн дугаар					
Регистрийн дугаар					
Үүсгэн байгуулагдсан огноо	Он		Сар		Өдөр
Хуулийн этгээдийн хэлбэр	<input type="checkbox"/> Хувьцаат компани <input type="checkbox"/> Хязгаарлагдмал хариуцлагатай компани				
Хөрөнгө оруулалтын хэлбэр	<input type="checkbox"/> Дотоодын хөрөнгө оруулалттай <input type="checkbox"/> Гадаадын хөрөнгө оруулалттай				
Бизнесийн болон үйл ажиллагааны чиглэл					
Хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийн мэдээлэл	Овог нэр Регистрийн дугаар				
Оруулсан хувь нийлүүлсэн хөрөнгө			₮		
Хаяг байршил	Аймаг/ хот				
	Сум/дүүрэг				
	Баг/хороо				
	Гудамж, байр				
	Тоот				
	Холбоо барих утас				
Цахим хуудас					
Цахим хаяг					
Компанийн тухай хуулийн 6.14-д заасан компанийн нэгдлийн оролцогч эсэх?				Тийм <input type="checkbox"/>	Үгүй <input type="checkbox"/>
Тийм бол доорх мэдээллийг нэгдлийн оролцогч бүрээр бөглөнө үү.					
Оноосон нэр					
Регистрийн дугаар					
Компанийн хэлбэр	<input type="checkbox"/> Хувьцаат компани		<input type="checkbox"/> Хязгаарлагдмал хариуцлагатай компани		
Тусгай зөвшөөрөл хүсэгч компанитай ямар холбоотой болох			<input type="checkbox"/> Толгой охин	<input type="checkbox"/> хараат зэргэлдээ	

Байгуулагдсан огноо	Он		Сар		Өдөр		
Үйлчилгээний төрөл							
Хаяг	Аймаг/ хот						
	Сум/дүүрэг						
	Баг/хороо						
	Гудамж, байр						
	Тоот						
Холбоо барих утас							
Цахим хуудас:							
Цахим хаяг:							
2. Хувьцаа эзэмшигч нь иргэн бол доорх мэдээллийг үнэн зөв бөглөнө үү.							
Овог							
Нэр							
Регистрийн дугаар							
Албан ёсны хаяг байршил							
Эрхэлж байгаа ажил, албан тушаал							
Ажлын хаяг							
Эзэмшсэн мэргэжил							
Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ			₮				
Харилцах дансны үлдэгдэл			₮				
Хадгаламжийн дансны үлдэгдэл			₮				
Хэсэг 4. Удирдлага боловсон хүчинтэй холбоотой мэдээлэл							
ТУЗ-тэй байх эсэх			Тийм <input type="checkbox"/>	Үгүй <input type="checkbox"/>	Бүрэлдэхүүний тоо		
Хяналтын зөвлөлтэй байх эсэх			Тийм <input type="checkbox"/>	Үгүй <input type="checkbox"/>			
Дотоод хяналтын нэгжтэй байх эсэх			Тийм <input type="checkbox"/>	Үгүй <input type="checkbox"/>			
Нийт ажилтан, албан хаагчдын тоо							
Албан тушаал	Овог	Нэр	Харьяалал	РД	Утасны дугаар	Эзэмшсэн мэргэжил	Дипломын дугаар
ТУЗ-ийн дарга							
ТУЗ-ийн гишүүн							
Хяналтын Зөвлөл болон дотоод хяналтын нэгжийн дарга							
Хяналтын Зөвлөл болон дотоод хяналтын нэгжийн гишүүн							
Гүйцэтгэх захирал							
Нягтлан бодогч							
Брокер							
Агент							
Тэмдэглэл: (Дээрх мэдээллийг албан тушаалтан бүрээр бичнэ.)							
Хэсэг 5. Үйл ажиллагаа явуулах ажлын байрны мэдээлэл							

Худалдаж авсан	<input type="checkbox"/>				
Түрээсэлсэн	<input type="checkbox"/>				
Бусад	<input type="checkbox"/>				
<i>Тэмдэглэл: Үйл ажиллагаа явуулах ажлын байр нь хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээн дэх хаяг байршил, дүрэмд тусгагдсан хаяг байршилтай ижил байна.</i>					
Хэсэг 6. Ашиглах техник, тоног төхөөрөмж, програм хангамжийн мэдээлэл					
Техник, тоног төхөөрөмжийн нэр төрөл	Техникийн үзүүлэлт	Худалдан авсан	Түрээслэсэн	Тоо ширхэг	Үнэ ₮
		<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>		
		<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>		
<i>Тэмдэглэл: (Дээрх мэдээллийг техник, тоног төхөөрөмж бүрээр бичнэ.)</i>					
Програм хангамжийн нэр төрөл	Програмын зориулалт	Худалдан авсан	Түрээслэсэн	Тоо ширхэг	Үнэ ₮
<i>Тэмдэглэл: (Дээрх мэдээллийг програм хангамж бүрээр бичнэ.)</i>					
Хэсэг 7. Тусгай зөвшөөрөлтэйгөөр эрхлэх үйл ажиллагааны төлөвлөлт					
Үзүүлэлтүүд		Он	Он	Он	
Харилцагч үйлчлүүлэгчдийн тоо					
Эх үүсвэрийн өртөг	₮				
Нийт орлого	₮				
Нийт зарлага	₮				
Хүлээгдэж буй ашиг	₮				
Өөрийн хөрөнгийн өгөөж	₮				
Активын өгөөж	₮				

Монгол улсын Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль, энэ журам болон бусад холбогдох хууль тогтоомжийн дагуу эрхлэх тусгай зөвшөөрөл авахад шаардагдах баримт бичгийг үнэн зөв бүрдүүлж, хүргүүлэв. Бүрдүүлсэн баримт бичигт ямар нэг худал ташаа зүйл орсон байвал хариуцлагыг бид хүлээх болно.

Манай өргөдөл, баримт бичгийг хүлээн авч, хянан шийдвэрлэж, үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг олгоно уу.

Тусгай зөвшөөрөл авснаас хойш Монгол улсын Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, Санхүүгийн зохицуулах хорооноос өгсөн үүрэг даалгаврыг биелүүлж ажиллах болно.


Өргөдөл гаргасан:

Эрх бүхий албан тушаалтан

гарын үсэг

огноо

Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны 3 дугаар сарын
11-ний өдрийн 12-р тогтоолын хавсралтаар батлагдсан
“Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын
үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл,
эрх олголт, бүртгэлийн журам”-ын 2-р хавсралт



ҮЛ ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГӨ ЗУУЧЛАЛЫН БАЙГУУЛЛАГЫН ЗӨВШӨӨРӨЛ ХҮСЭХ ӨРГӨДӨЛ

Өргөдөл гаргасан огноо	Он		Сар		Өдөр		
Өргөдөл/хүсэлт гаргагч үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын оноосон нэр							
Регистрийн дугаар							
Зөвшөөрлийн төрлийг сонгоно уу.							
<input type="checkbox"/> Хувь нийлүүлсэн хөрөнгө, хувьцаа эзэмшигчдийн бүтэц, бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах <input type="checkbox"/> Салбар байгуулах <input type="checkbox"/> Оноосон нэр өөрчлөх							
Хэсэг 1. Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, хувьцаа эзэмшигчдийн бүтэц, бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах							
<input type="checkbox"/> Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнд өөрчлөлт оруулах <input type="checkbox"/> Хувьцаа эзэмшигчдийн бүтэц, бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах							
А. Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнд өөрчлөлт оруулах							
Оноосон нэр/Овог нэр	РД	Одоогийн ХНХ хэмжээ (₮)	Нэмэгдсэн (₮)	Хорогдсон (₮)	Өөрчлөлт орсны дараах ХНХ хэмжээ (₮)	ХНХ-д эзлэх хувь (%)	
Тэмдэглэл: (Дээрх мэдээллийг хувьцаа эзэмшигч бүрээр бичнэ.)							
Б. Хувьцаа эзэмшигчдийн бүтэц, бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах							
Этгээд	Оноосон нэр	Овог нэр	Харьяалал	РД	Хувьцааны тоо (ш)	ХНХ-ийн хэмжээ (₮)	ХНХ-д эзлэх хувь (%)
Хэсэг 2. Салбар байгуулах							
Салбар шийдвэр	байгуулах	Он		Сар		Өдөр	Дугаар
Чиглэл							
Хаяг байршил		Аймаг/ хот					
		Сум/дүүрэг					

		Баг/хороо					
		Гудамж,байр					
		Тоот					
		Холбоо барих утас					
Цахим хуудас							
Цахим хаяг							
Салбарын удирдах албан тушаалтны мэдээлэл							
Салбарын нийт ажилтан, албан хаагчдын тоо							
Албан тушаал	Овог	Нэр	Харъяалал	РД	Утасны дугаар	Эзэмшсэн мэргэжил	Дипломны дугаар
Брокер							
Агент							
<i>Тэмдэглэл: (Дээрх мэдээллийг ажилтан бүрээр бичнэ.)</i>							
Салбарын үйл ажиллагааны төлөвлөлт							
Үзүүлэлтүүд	Он		Он		Он		
Харилцагч үйлчлүүлэгчдийн тоо							
Эх үүсвэрийн өртөг	₮						
Нийт орлого	₮						
Нийт зарлага	₮						
Хүлээгдэж буй ашиг	₮						
Өөрийн хөрөнгийн өгөөж	₮						
Активын өгөөж	₮						
Үйл ажиллагаа явуулах ажлын байрны мэдээлэл							
Худалдаж авсан	<input type="checkbox"/>						
Түрээсэлсэн	<input type="checkbox"/>						
Бусад	<input type="checkbox"/>						
Ашиглах техник тоног төхөөрөмж, програм хангамжийн мэдээлэл							
Техник, тоног төхөөрөмжийн нэр төрөл	Техникийн үзүүлэлт	Худалдан авсан	Түрээс лэсэн	Тоо ширхэг	Үнэ ₮		
		<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>				
		<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>				
<i>Тэмдэглэл: (Дээрх мэдээллийг техник, тоног төхөөрөмж бүрээр бичнэ.)</i>							
Програм хангамжийн нэр төрөл	Програмын зориулалт	Худалдан авсан	Түрээс лэсэн	Тоо ширхэг	Үнэ ₮		
		<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>				
		<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>				
<i>Тэмдэглэл: (Дээрх мэдээллийг програм хангамж бүрээр бичнэ.)</i>							
Хэсэг 3. Оноосон нэр өөрчлөх							
Хуучин нэр			Регистрийн дугаар				
Шинэчилсэн нэр							

Оноосон нэрийг өөрчлөх болсон шалтгаан	
---	--

Энэ журам болон холбогдох бусад хууль тогтоомжид нийцүүлэн зөвшөөрөл авахад шаардагдах баримт бичгийг үнэн зөв бүрдүүлж, хүргүүлэв. Бүрдүүлсэн баримт бичигт ямар нэг худал ташаа зүйл орсон байвал хариуцлагыг бид хүлээх болно.

Манай өргөдөл, баримт бичгийг хүлээн авч, хянан шийдвэрлэж, зөвшөөрлийг олгоно уу.
Өргөдөл гаргасан:

Эрх бүхий албан тушаалтан

гарын үсэг

огноо

Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны 3 дугаар сарын
11-ний өдрийн 12-р тогтоолын хавсралтаар батлагдсан
“Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын
үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл,
эрх олголт, бүртгэлийн журам”-ын 3-р хавсралт



**ҮЛ ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГӨ ЗУУЧЛАЛЫН БАЙГУУЛЛАГЫН НЭМЖ ЭРХЛЭХ
ҮЙЛЧИЛГЭЭ БОЛОН ҮЙЛ АЖИЛЛАГААТАЙ ХОЛБООТОЙ ӨӨРЧЛӨЛТИЙГ
БҮРТГҮҮЛЭХ ӨРГӨДӨЛ**

Өргөдөл гаргасан огноо	Он		Сар		Өдөр	
Өргөдөл/хүсэлт гаргагч үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын нэр						
Регистрийн дугаар						
<i>Тусгай зөвшөөрлийн хүрээнд нэмж эрхлэх үйлчилгээний төрлийг сонгоно уу.</i>						
<input type="checkbox"/> Үл хөдлөх эд хөрөнгийн менежментийн үйлчилгээ <input type="checkbox"/> Үл хөдлөх эд хөрөнгийг худалдан авч, засварлан борлуулах үйлчилгээ <input type="checkbox"/> Хорооноос үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын үйл ажиллагаанд хамаарна гэж үзсэн бусад үйлчилгээ.						
<i>Үйл ажиллагаатай холбоотой өөрчлөлтийг бүртгүүлэх мэдээллийн төрлийг сонгоно уу.</i>						
<input type="checkbox"/> Эрх бүхий албан тушаалтны өөрчлөлт <input type="checkbox"/> Брокер, агентын өөрчлөлт <input type="checkbox"/> Хаяг байршлын өөрчлөлт						
Хэсэг 1. Эрх бүхий албан тушаалтны өөрчлөлт						
Албан тушаал	Овог, нэр	Харъяалал	РД	Утасны дугаар		
<i>Тэмдэглэл (Өөрчлөлт оруулсан хүн тус бүрээр бичнэ)</i>						
Хэсэг 2. Брокер, агентын өөрчлөлт						
Албан тушаал	Овог, нэр	Харъяалал	РД	Утасны дугаар		
<i>Тэмдэглэл (Өөрчлөлт оруулсан хүн тус бүрээр бичнэ)</i>						
Хэсэг 3. Хаяг байршилд өөрчлөлт оруулах						
Өөрчлөлт оруулсан хаяг байршил	Өөрчлөлт орж буй нэгжийн нэр					
	Аймаг/ хот					

	Сум/дүүрэг	
	Баг/хороо	
	Гудамж,байр	
	Тоот	
	Холбоо барих утас	

Энэ журам болон холбогдох бусад хууль тогтоомжид нийцүүлэн бүртгүүлэхэд шаардагдах баримт бичгийг үнэн зөв бүрдүүлж, хүргүүлэв. Бүрдүүлсэн баримт бичигт ямар нэг худал ташаа зүйл орсон байвал хариуцлагыг бид хүлээх болно.

Манай өргөдөл, баримт бичгийг хүлээн авч, хянан шийдвэрлэж, бүртгэж өгнө үү.


Өргөдөл гаргасан:

Эрх бүхий албан тушаалтан

гарын үсэг

огноо

Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны 3 дугаар сарын
11-ний өдрийн 4-р тогтоолын хавсралтаар батлагдсан
“Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын
үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл,
эрх олголт, бүртгэлийн журам”-ын 4-р хавсралт




ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ АВАХ ХҮСЭЛТ ГАРГАХАД БҮРДҮҮЛЭХ БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ

№	Баримт бичгийн төрөл	Хуудасны тоо
1	Энэхүү журмын 1 дүгээр хавсралтаар баталсан маягтын дагуу тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөл	
2	Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын үйл ажиллагаа эрхлэх тухай төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол хувьцаа эзэмшигчдийн хурал/-ийн шийдвэрийн эх хувь эсхүл нотариатаар баталгаажуулсан хуулбар	
3	<p>Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүсэгч хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний нотариатаар баталгаажуулсан хуулбар, гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн хувьд Гадаадын хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан төрийн байгууллагаас олгосон гэрчилгээний нотариатаар баталгаажуулсан хуулбараас гадна дараах бичиг баримтыг ирүүлнэ.</p> <ol style="list-style-type: none"> 1. Харьяалах улс, оронд зээл, батлан даалтын гэрээгээр хүлээсэн хугацаа хэтэрсэн аливаа өргүй болохыг нотлох баримт бичиг; 2. Харьяалах улс, оронд гааль, татварын өртэй эсэхийг харуулсан баримт бичиг; 3. Харьяалах улс, оронд ял шийтгэлгүй болохыг нотлох баримт бичиг; 4. Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх үйл ажиллагаа, гэмт хэрэгт оролцож байгаагүй болохыг нотлох баримт бичиг. 	
4	<p>Улсын бүртгэлд бүртгүүлсэн компанийн дүрэм. Тус дүрэмд Компанийн тухай хуулийн 16 дугаар зүйлд зааснаас гадна дараах зүйлийг тусгасан байна:</p> <ol style="list-style-type: none"> 1. хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, бүтцэд өөрчлөлт оруулах нөхцөл; 2. хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдах журам, их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл 	

	<p>хийхэд баримтлах журам, энэ талаарх удирдлагын бүрэн эрх;</p> <p>3. хувьцаа эзэмшигчдийн хурал, төлөөлөн удирдах зөвлөл болон Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих ажилтны эрх, үүрэг, хариуцлага;</p> <p>4. хувьцаа арилжих, бусдад шилжүүлэх, харилцан хязгаарлалт хийх үйл ажиллагааны зохицуулалт;</p> <p>5. татан буугдах үндэслэл, удирдлага, брокер, агентийн буруутай үйл ажиллагаанаас хөрөнгө оруулагч, харилцагчдад учруулсан хохирлыг барагдуулах арга хэлбэр, хариуцлага хүлээх зарчим.</p>	
5	Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдийн хувь нийлүүлсэн хөрөнгийн эх үүсвэр нь хууль ёсны орлогоос бүрдсэн болохыг нотлох бичиг баримт, гарал үүслийн талаарх тодорхойлолт	
6	Хувьцаа эзэмшигч нь хуулийн этгээд бол эцсийн өмчлөгчийн талаарх мэдээлэл	
7	Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдийн хувь нийлүүлсэн хөрөнгөд ногдох мөнгөн хөрөнгийг өөрийн харилцагч банкны дансанд байршуулсан талаарх банкны тодорхойлолт, бусад баталгаа	
8	Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 14.1-т заасан дотоод хяналтын болон эрсдэлийн удирдлагын хөтөлбөр	
9	Сүүлийн жилийн санхүүгийн тайлан, шинээр үүсгэн байгуулж байгаа бол эхлэлтийн баланс	
10	Брокер, агентуудын энэ журмын 2.1.6-д заасан гэрчилгээний хуулбар, энэ журмын 12, 13 дугаар хавсралтын дагуу гаргасан тодорхойлолт	
11	Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих ажилтны энэ журмын 12 дугаар хавсралтын дагуу гаргасан тодорхойлолт	
12	Ажлын байр нь компанийн өөрийн байр бол үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээ, түрээсийн байр бол түрээсийн гэрээний нотариатаар баталгаажуулсан хуулбар	

13	Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагааг зохицуулсан дотоод журам, ажилтнуудын ёс зүйн журам;	
14	Бизнесийн төлөвлөгөө	
15	Үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдийн дотоод зохион байгуулалтын бүтэц, танилцуулга	
16	Үндсэн үйл ажиллагаанд ашиглах техник тоног төхөөрөмжийн жагсаалт	
17	Энэ журмын 5.1 дэх хэсэгт заасан этгээдүүд нь тохиромжтой этгээдийг тодорхойлох шалгуурыг хангасан эсэхийг нотлох баримт	


Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны 3 дугаар сарын
11-ний өдрийн 12-р тогтоолын хавсралтаар батлагдсан
“Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын
үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл,
эрх олголт, бүртгэлийн журам”-ын 5-р хавсралт



**ҮЛ ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГӨ ЗУУЧЛАЛЫН БАЙГУУЛЛАГЫН ХУВЬ
НИЙЛҮҮЛСЭН ХӨРӨНГӨ, ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН БҮТЭЦ,
БҮРЭЛДЭХҮҮНД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ЗӨВШӨӨРӨЛ АВАХАД БҮРДҮҮЛЭХ
БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ**

№	Баримт бичгийн төрөл	Хуудасны тоо
1	Энэ журмын 2 дугаар хавсралт дахь маягтын дагуу хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, хувьцаа эзэмшигчдийн бүтэц, бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах зөвшөөрөл хүссэн өргөдөл	
2	Өөрчлөлт оруулахыг зөвшөөрсөн хувьцаа эзэмшигчдийн хурлын тэмдэглэл, шийдвэр, холбогдох гэрээ хэлцэл, нотлох баримт бичиг	
3	Иргэний хуулийн дагуу өмчлөх эрхээ өвлүүлсэн, бэлэглэсэн тухай хэлцэл, нотлох баримт бичиг	
4	Шинээр орж буй хувьцаа эзэмшигч нь энэ журмын 5 дугаар бүлэгт заасан тохиромжтой этгээдийг тодорхойлох шалгуурыг хангасан эсэхийг нотлох баримт бичиг	
5	Шинээр орж буй хувьцаа эзэмшигчийн хувь нийлүүлсэн хөрөнгөд оруулах мөнгөн хөрөнгийн гарал үүсэл нь хууль ёсны орлогоос бүрдсэн эсэхийг нотлох баримт бичиг	
6	Хувьцаа эзэмшигч нь хуулийн этгээд бол эцсийн өмчлөгчийн талаарх мэдээлэл	
7	Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, хувьцаа эзэмшигчдийн бүтэц, бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулахтай холбогдуулан байгууллагын дүрэмд орох нэмэлт өөрчлөлтийн эх хувь	


Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны 3 дугаар сарын
11-ний өдрийн 4-р тогтоолын хавсралтаар батлагдсан
“Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын
үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл,
эрх олголт, бүртгэлийн журам”-ын 6-р хавсралт



**ҮЛ ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГӨ ЗУУЧЛАЛЫН БАЙГУУЛЛАГЫН САЛБАР
БАЙГУУЛАХ ЗӨВШӨӨРӨЛ АВАХАД БҮРДҮҮЛЭХ БАРИМТ БИЧГИЙН
ЖАГСААЛТ**

№	Баримт бичгийн төрөл	Хуудасны тоо
1	Энэ журмын 2 дугаар хавсралт дахь маягтын дагуу салбар байгуулах зөвшөөрөл хүссэн өргөдөл	
2	Салбар байгуулах эрх бүхий этгээдийн шийдвэр	
3	Ажлын байр нь компанийн өөрийн байр бол үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээ, түрээсийн байр бол түрээсийн гэрээний нотариатаар баталгаажуулсан хуулбар	
4	Үйл ажиллагаанд ашиглах техник тоног төхөөрөмжийн жагсаалт	
5	Тухайн нутаг дэвсгэрт салбар байгуулан ажиллуулахтай холбогдсон зах зээлийн судалгаа	
6	Салбарын дотоод хяналт болон бусад үйл ажиллагааг зохицуулах журам	
7	Салбарт ажиллах брокер, агентын энэ журмын 2.1.6-д заасан гэрчилгээний хуулбар, энэ журмын 12, 13 дугаар хавсралтын дагуу гаргасан тодорхойлолт	
8	Нэмэлт өөрчлөлт оруулсан дүрэм	


Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны 3 дугаар сарын
11-ний өдрийн 12-р тогтоолын хавсралтаар батлагдсан
“Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын
үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл,
эрх олголт, бүртгэлийн журам”-ын 7-р хавсралт



**ҮЛ ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГӨ ЗУУЧЛАЛЫН БАЙГУУЛЛАГЫН ОНООСОН НЭР
ӨӨРЧЛӨХ ЗӨВШӨӨРӨЛ АВАХАД БҮРДҮҮЛЭХ
БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ**

№	Баримт бичгийн төрөл	Хуудасны тоо
1	Энэ журмын 3 дугаар хавсралт дахь маягтын дагуу оноосон нэр өөрчлөх зөвшөөрөл хүссэн өргөдөл	
2	Оноосон нэр өөрчлөх тухай эрх бүхий этгээдийн шийдвэр	
3	Улсын бүртгэлийн байгууллагаас авсан хуулийн этгээдийн оноосон нэрийн баталгаажуулалтын хуудас	
4	Өөрчлөлт оруулсан дүрмийн эх хувь	
5	Тусгай зөвшөөрлийн гэрчилгээ, гэрчилгээний хавсралтын эх хувь	


Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны 3 дугаар сарын
11-ний өдрийн 2-р тогтоолын хавсралтаар батлагдсан
“Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын
үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл,
эрх олголт, бүртгэлийн журам”-ын 8-р хавсралт



**ҮЛ ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГӨ ЗУУЧЛАЛЫН БАЙГУУЛЛАГЫН ЭРХЛЭХ
ҮЙЛЧИЛГЭЭГ БҮРТГҮҮЛЭХЭД БҮРДҮҮЛЭХ БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ**

№	Баримт бичгийн төрөл	Хуудасны тоо
1	Энэ журмын 2 дугаар хавсралтын дагуу гаргасан өргөдөл	
2	Тухайн үйлчилгээг эрхлэх талаар гаргасан хувьцаа эзэмшигчдийн шийдвэр	
3	Бизнес төлөвлөгөө	
4	Тухайн үйлчилгээ эрхэлснээс үүсч болзошгүй эрсдэл, эрсдэлийг бууруулахад хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө	


Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны 3 дугаар сарын
11-ний өдрийн 12-р тогтоолын хавсралтаар батлагдсан
“Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын
үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл,
эрх олголт, бүртгэлийн журам”-ын 9-р хавсралт



**ҮЛ ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГӨ ЗУУЧЛАЛЫН БАЙГУУЛЛАГЫН ЭРХ БҮХИЙ
АЛБАН ТУШААЛТАН, БРОКЕР, АГЕНТЫН ӨӨРЧЛӨЛТИЙГ БҮРТГҮҮЛЭХЭД
БҮРДҮҮЛЭХ БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ**

№	Баримт бичгийн төрөл	Хуудасны тоо
1	Энэ журмын 3 дугаар хавсралтын дагуу гаргасан өргөдөл	
2	Шинээр томилогдож буй эрх бүхий албан тушаалтан нь энэ журмын 5 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан эсэхийг нотлох баримт бичиг, холбогдох шийдвэр, энэ журмын 12, 13 дугаар хавсралтын дагуу гаргасан тодорхойлолт	
3	Шинээр томилогдож буй брокер, агентын энэ журмын 2.1.6-д заасан гэрчилгээний хуулбар, энэ журмын 12, 13 дугаар хавсралтын дагуу гаргасан тодорхойлолт	


Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны 3 дугаар сарын
11-ний өдрийн 12-р тогтоолын хавсралтаар батлагдсан
“Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын
үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл,
эрх олголт, бүртгэлийн журам”-ын 10-р хавсралт



**ҮЛ ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГӨ ЗУУЧЛАЛЫН БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА
ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙГ СЭРГЭЭХ ХҮСЭЛТ ГАРГАХАД БҮРДҮҮЛЭХ
БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ**

№	Баримт бичгийн төрөл	Хуудасны тоо
1	Тусгай зөвшөөрлийн хүрээнд эрхлэх үйл ажиллагааг түдгэлзүүлсэн үндэслэл бүхий зөрчил дутагдлыг арилгаж, өгсөн үүрэг даалгаврыг биелүүлсэн талаарх тайлан, түүнийг нотлох баримт бичиг	
2	Хорооноос шаардсан нэмэлт тодруулга, баримт бичиг.	


Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны 3 дугаар сарын
11-ний өдрийн 11-р тогтоолын хавсралтаар батлагдсан
“Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын
үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл,
эрх олголт, бүртгэлийн журам"-ын 11-р хавсралт



**ҮЛ ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГӨ ЗУУЧЛАЛЫН БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА
ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙГ ХҮЧИНГҮЙ БОЛГОХОД БҮРДҮҮЛЭХ
БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ**

№	Баримт бичгийн төрөл	Хуудасны тоо
1	Тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох асуудлыг хэлэлцсэн эрх бүхий этгээдийн шийдвэр, тэмдэглэл	
2	Хүсэлт гаргах өдрийн байдлаарх санхүүгийн тайлан мэдээ	
3	Хувь нийлүүлсэн хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэл	
4	Авлага, өглөгийн дэлгэрэнгүй бүртгэл	
5	Үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэл	
6	Тэнцлийн гадуурх дансны дэлгэрэнгүй бүртгэл	
7	Хорооноос шаардсан нэмэлт тодруулга, баримт бичиг.	

Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны 3 дугаар сарын
11-ний өдрийн 12-р тогтоолын хавсралтаар батлагдсан
“Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын
үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл,
эрх олголт, бүртгэлийн журам”-ын 12-р хавсралт



ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТАН БОЛОН БУСАД БОЛОВСОН ХҮЧНИЙ ТОДОРХОЙЛОЛТ

Компанийн тухай хуулийн 84.1-д заасан эрх бүхий албан тушаалтан, хувьцаа эзэмшигч,
эцсийн өмчлөгч, брокер, агентын талаарх мэдээлэл

1. Ерөнхий мэдээлэл

Ургийн овог	
Овог нэр	
Регистрийн дугаар	
Иргэний харьяалал	
Эрхлэж байгаа ажил, албан тушаал	
Оршин суугаа газрын хаяг	
Гар утасны дугаар	
Цахим хаяг	
Ажлын хаяг	
Цахим хаяг	

3x4
Зураг

2. Боловсрол /Ерөнхий боловсролын сургуулийг оролцуулан бичнэ/

№	Төгссөн сургууль	Эзэмшсэн мэргэжил	Элссэн он	Төгссөн он	Диплом, гэрчилгээний дугаар

3. Ажлын туршлага

№	Хаана ажиллаж байсан	Албан тушаал	Ажилд орсон он, сар, өдөр	Ажлаас гарсан он, сар, өдөр	Шалтгаан

4. ТУЗ-ийн дарга, гишүүн, гүйцэтгэх удирдлага, хувьцаа эзэмшигч, эцсийн өмчлөгч, брокер, агентын холбогдох этгээдийн байдал:

Компанийн тухай хуулийн 89.2-т заасан нэгдмэл сонирхолтой этгээдийн мэдээлэл

№	Таны хэн болох	Овог, нэр /Хуулийн этгээдийн нэр/	Регистрийн дугаар	Эрхлэж буй ажил, албан тушаал

ТОДОРХОЙЛОЛТ ГАРГАСАН:


/.....//...../...../

/Овог, нэр/

/гарын үсэг/

огноо

Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны 3 дугаар сарын
11-ний өдрийн /20/ -р тогтоолын хавсралтаар батлагдсан
“Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын
үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл,
эрх олголт, бүртгэлийн журам”-ын 13-р хавсралт



САНХҮҮГИЙН
ЗОХИЦУУЛАХ ХОРОО
FINANCIAL REGULATORY COMMISSION
OF MONGOLIA

ТОХИРОМЖТОЙ ЭТГЭЭДИЙН ТОДОРХОЙЛОЛТ

1. Тодорхойлолт бөглөж буй этгээдийн овог, нэр -----
2. Компанийн нэр -----
3. Компанид ямар хамааралтай болох:
 - Хувьцаа эзэмшигч
 - Компанийн эрх бүхий албан тушаалтан/дурдах/ -----
 - Компанийн 10 буюу түүнээс дээш хувийн хувьцааг эзэмшигч
 - Хувьцаа эзэмшигч, компанийн эрх бүхий албан тушаалтан
 - Компанийн нэгдлийн гишүүн компанийн хувьцаа эзэмшигч
 - Компанийн нэгдлийн гишүүн компанийн эрх бүхий албан тушаалтан
 - Брокер
4. Хувийн санхүүгийн байдал хэвийн эсэх Тийм Үгүй
5. Татварын байгууллагад өр төлбөртэй эсэх
 - Үгүй Тийм /тийм бол тайлбар бичих/ _____
6. Хугацаа хэтэрсэн зээлийн өртэй эсэх
 - Үгүй Тийм /тийм бол тайлбар бичих/ _____
7. Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, авлига, хээл хахууль, эдийн засгийн гэмт хэрэгт ял шийтгүүлж байсан эсэх

Үгүй Тийм /тийм бол тайлбар бичих/-----

8. Сүүлийн 5 жилийн хугацаанд салбарын ёс зүйн дүрмийг зөрчсөн эсэх;

Үгүй Тийм /тийм бол тайлбар бичих/-----

9. Сүүлийн 5 жилд зөрчлийн улмаас тусгай зөвшөөрөл нь хүчингүй болсон санхүүгийн зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллагад төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүн, гүйцэтгэх удирдлагад ажиллаж байсан эсэх

Үгүй Тийм /тийм бол тайлбар бичих/-----

10. Хувийн шалтгаанаар эрүүгийн хариуцлага хүлээж байсан эсэх

Үгүй Тийм /тийм бол тайлбар бичих/-----

11. Гүйцэтгэх захирал, брокер, агент нь өөр байгууллагад үндсэн ажилтнаар давхар ажил, хөдөлмөр эрхэлдэг эсэх

Үгүй Тийм /тийм бол тайлбар бичих/-----

12. Бусад -----

*-тайлбараа хуудас хавсарган бичиж болно.

Энэхүү мэдүүлгийг худал мэдүүлбэл тохиромжтой этгээд бус гэж үзэх үндэслэл болно.

Гарын үсэг -----

Огноо -----